



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/696

Булган сум

┌ Үзэсгэлэн худалдаа зохион байгуулах тухай ┐

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18 дугаар зүйлийн 18.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын 2.1.6, аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.5.3.1, аймгийн Засаг даргын 2024 оны А/632 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг дэмжиж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, түншлэлийг хөгжүүлэх, хүн амыг эрүүл аюулгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах зорилгоор "Миний Булганы Алтан намар 2024" үзэсгэлэн худалдааг Булган суманд 2024 оны 10 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд зохион байгуулсугай.

2. Арга хэмжээ зохион байгуулах ажлын хэсгийг 1 дүгээр, удирдамжийг 2 дугаар, шаардагдах хөрөнгийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Үзэсгэлэн худалдаанд сум орон нутгийнхаа үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг бэлтгэл сайтай өргөн хүрээтэй оролцуулж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Жаргалсайхан)-д даалгасугай.

4. Арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай 3,980,000 (гурван сая есөн зуун наян мянга) төгрөгийг Хөтөлбөр төлөвлөгөө арга хэмжээний зардлын 16 дахь арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



10.. дугаар сарын 12-ны ний өдрийн 1636.. дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



"Миний Булганы Алтан намар 2024" үзэсгэлэн худалдаа зохион байгуулах ажлын хэсэг

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Жаргалсайхан (Аймгийн Засаг даргын орлогч)
Гишүүд: Г.Давааням (Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга)
М.Батчимэг (Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)
Ч.Амгалан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга)
Н.Батжаргал (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
Ц.Бүрэнтуяа (Стандарт хэмжилзүйн хэлтсийн дарга)
М.Мөнхбат (Статистикийн хэлтсийн дарга)
О.Ууганчимэг (Хөгжимт жүжгийн театрын дарга)
Л.Алтанцэцэг (Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны дарга)
П.Нөхөрлөлбаяр (Булган сумын Засаг дарга)
Сумын Засаг дарга нар
Н.Пүрэвсайхан (Булган аймаг дахь Политехникийн коллеж)
Д.Ганхуяг (Төрийн банкны захирал)
Д.Оюунгэрэл (Аймгийн Худалдаа аж үйлдвэрийн танхимын дарга)
Нарийн бичгийн дарга: Д.Мөнхбаасан (Хүнс, хөдөө аж ахуйн газрын Үйлдвэр худалдааны албаны дарга)

Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 24-ны ний өдрийн А/656 дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт

**"МИНИЙ БУЛГАНЫ АЛТАН НАМАР 2024" ҮЗЭСГЭЛЭН
ХУДАЛДАА ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ**

Зорилго: Орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээний борлуулалтыг дэмжиж, үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, түншлэлийг хөгжүүлэх, хүн амыг эрүүл аюулгүй, экологийн цэвэр бүтээгдэхүүнээр хангах, Төрийн банкны харилцагчдын бизнесийг өргөжүүлэхэд оршино.

Ерөнхий зохион байгуулагч: - Булган аймгийн Засаг даргын Тамгын газар

Хамтран зохион байгуулагч: - Хүнс, хөдөө аж ахуйн газар

- Төрийн банк
- Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
- Стандарт, хэмжилзүйн хэлтэс
- Булган сумын ЗДТГ
- Булган аймаг дахь Политехникийн коллеж

Хугацаа, байршил: 2024 оны 10 дугаар сарын 24-25-ны өдрүүдэд Булган сум Спортын ордны Б заланд үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдана.

Хамрах хүрээ:

- Сумын Засаг даргын Тамгын газар
- Сумын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч
- Булган нутгийн үржил шимт хөрсөнд ургасан органик хүнсний ногоо, бүх төрлийн буудайн бүтээгдэхүүн
- Хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн
- Мал, махны худалдаа
- Модон эдлэл-Барилгын материал
- Хөнгөлттэй зээлийн дэмжлэгт хамрагдсан иргэн, өрх, бүл, хоршоо, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллага
- Ойн нөхөрлөл, малчин, фермер, тариаланч зэрэг бүх төрлийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид оролцоно.

Нэг: Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

- Бүтээгдэхүүний амталгаат худалдаа /борлуулалт/
- Аж ахуйн нэгж байгууллага /бүтээгдэхүүн/-ын танилцуулга, мэдээлэл хийгдэх
- Үйлдвэрлэл эрхлэгч хоорондын хамтын ажиллагаа, туршлага судлах
- Мал, махны худалдаа зохион байгуулах тул малчид болон мал махны ченжүүдэд мэдээллийг хариуцлагатай хүргэх
- Бүх төрлийн тарьц, суулгацын борлуулалт хийх
- Хөдөлмөр жуулчлалын ширээ ажиллаж, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвүүдийн үйл ажиллагааны танилцуулга сурталчилгаа зохион байгуулагдана.

Хоёр: Зохион байгуулалтын бусад ажлын талаар

Сумдаас үзэсгэлэн худалдаанд оролцох үйлдвэрлэл эрхлэгчдийг Сумын Засаг даргын орлогч ахалж, жижиг, дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтний хамт ирнэ.

- 2024 оны 10 дүгээр сарын 20- 24-нд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт үзэсгэлэн худалдаанд оролцогчдын бүртгэнэ.

Гурав: Үзэсгэлэн худалдааны үеэр мөрдөх журам

Үйлдвэрлэгч бүр өөрийн бүтээгдэхүүнийг танилцуулах сурталчилгааны материал, гарын авлага хэвлүүлсэн байна.

Үзэсгэлэн худалдааны байр талбайд бүтээгдэхүүнийг зөөвөрлөх, тээвэрлэх, борлуулах үе шатанд хог хаягдлыг эмх цэгцтэй байлгаж, хог хаягдал хийх сав байршуулсан байна.

Бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтын саванд савлах, зориулалтын тэмдэг тэмдэглэгээтэй сав, баглаа боодлын асуудлыг шийдвэрлэж, эрүүл ахуйн шаардлага хангаж ажиллана.

Зохион байгуулагчаас авч буй үйлдвэрлэлт, борлуулалтын судалгаанд хамрагдаж үнэн зөв мэдээлэл өгөх үүрэг хүлээнэ.

Дөрөв: Үзэсгэлэн худалдааны үр дүн

Үзэсгэлэн худалдааны үр дүнг зохион байгуулах ажлын хэсэг нэгтгэж, тайлагнана.

Аймгийн Засаг даргын 2024 оны
10 дугаар сарын 22-ны ний өдрийн ... дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт

**Миний Булганы алтан намар 2024" үзэсгэлэн худалдаа
зохион байгуулахад шаардагдах төсөв**

д/д	Зардлын нэр	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ	Тайлбар
1	2	3	4	5	6
1	Нээлтийн үйл ажиллагаа, бусад зардал	1	200 000	200 000	АЗДТГ
2	Хулдаасан хэвлэл, дотор	20	15 000	300 000	АЗДТГ
3	Хулдаасан хэвлэл, гадна	20	15 000	300 000	АЗДТГ
4	Эх бэлтгэл	2	10 000	20 000	АЗДТГ
5	Бөгж бусад	1	50 000	50 000	АЗДТГ
6	Сумдын хаяг хэвлэл	20 м2	25 000	500 000	АЗДТГ
7	Асарын хаяг	4	15000	60 000	АЗДТГ
8	Заалны түрээс	3 хоног	500 000	1 500 000	АЗДТГ-1.0 сая Төрийн банк- 0.5 сая
9	Сандал ширээ,	4	30 000	120 000	Төрийн банк
10	Цагаан асар зөөх зардал	2	30 000	60 000	АЗДТГ
11	Орон нутгаас оролцогчдийн замын зардал	16	150 000	2 400 000	Төрийн банк
12	Нээлтийн арга хэмжээ /Морин хуур, дуучин, хөтлөгч	1	1 000 000	1 000 000	Төрийн банк
13	Дархан-Уул аймагт зохион байгуулагдсан "Намрын ногоон өдрүүд-2024" үзэсгэлэн худалдаанд аймгийн бизнес эрхлэгчдийн худалдаа хийх талбайн түрээс	3 өдөр	330 000	990 000	АЗДТГ
14	Ногооны жин таах тэмцээн	3 байр	35 000	105 000	ХХҮГ
15	Нийт			7 605 000	
16				3 980 000	АЗДТГ
17	Үүнээс:			3 520 000	Төрийн банк
18				105 000	ХХҮГ